



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/185

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 оны хагас жилийн үндсэн хөрөнгө, бараа материал, бэлэн мөнгөнд хяналт тавьж тооллого зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, тооллого хийх хуваарийг хоёрдугаар хавсралтаар, тооллогын комиссын ажиллах удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тооллогыг 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд санхүүгийн холбогдох баримтуудыг үндэслэн чанартай хийж, үлдэгдлийг баталгаажуулан, 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор тооллогын тайлан, актлах хөрөнгийн жагсаалтыг Өмч хамгаалах байнгын зөвлөлд хүргүүлэхийг тооллогын комисс (Х.Баярмаа)-т үүрэг болгосугай.

3.Иргэний нисэхийн үндэсний төвийн болон түүний харьяа салбар нэгжүүдийн жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг санхүүгийн холбогдох баримтуудыг үндэслэн чанартай хийж, үлдэгдлийг баталгаажуулан, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн дотор тооллогын комисст тайланг ирүүлэхийг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д үүрэг болгосугай.

4.Иргэний нисэхийн ерөнхий газрын жилийн эцсийн тооллого, тооцооны явц, үр дүнд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авах, холбогдон гарах зардлыг санхүүжүүлэн ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Д.Хатанбаатар)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал)-т нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА